

Монгол Улсын Иргэний хууль дахь тооцоо нийлэх гэрээний зохицуулалтыг тайлбарлах нь: Монгол Улсын дээд шүүхийн 2022 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 00176 дугаар тогтоолын жишээ дээр

**Interpreting Regulations on Current Account Contract
in the Mongolian Civil Code: Based on Mongolian
Supreme Court Decision, Feb 22, 2022 No.00176**

Рэнбаагийн Пүрэвбаатар

Хууль зүйн ухааны магистр (LL.M.)

*Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн
Хувийн эрх зүйн тэнхимийн багш,*

Улаанбаатар хот, Монгол Улс.

purevbaatar@num.edu.mn



[Товч утга]

Энэхүү судалгааны өгүүллээр Монгол Улсын Иргэний хууль дахь тооцоо нийлэх гэрээний зохицуулалтыг хэрхэн хэрэглэж, тайлбарлаж байгаа болохыг судалсан бөгөөд тооцоо нийлэх гэрээний урьдчилсан нөхцөл, үндсэн шинж болон тухайн гэрээ болон иргэний хууль дахь бусад институци болох үүргийг хүлээн зөвшөөрөх, харилцан шаардлага бүхий үүргийг тооцож дуусгавар болгох болон бусад холбогдох зохицуулалт хоорондын харилцан хамаарлын талаарх асуудлыг илрүүлэхийг зорилоо.

Монголын эрх зүй судлаачид өөрийн орны хувийн эрх зүйн тогтолцоо тэр дундаа Иргэний хуулийг Германы хувийн эрх зүйн тогтолцоо ялангуяа Иргэний хууль болон Арилжааны хуулийн хүчтэй нөлөөн дор боловсруулагдсан гэж үздэг. Германы хуулийн мэргэжилтнүүд (ялангуяа шүүхийн шүүгч нар) Иргэний хуулийн төслийг боловсруулах үйл явцад ихээхэн идэвхтэй оролцсон нь ч үүнийг гэрчилнэ. Тиймээс ч бусад олон зохицуулалттай нэгэн адилаар Монгол Улсын Иргэний хууль дахь тооцоо нийлэх гэрээний зохицуулалт ч гэсэн Германы Арилжааны хуулийн 355 болон 356 дугаар зүйлийн зохицуулалттай ихээхэн төсөөтэй байдлаар боловсруулагджээ. Энэ шалтгааны улмаас судлаач Иргэний хууль дахь тооцоо нийлэх гэрээний зохицуулалтыг Германы Арилжааны хуулийн холбогдох зохицуулалттай харьцуулан судлахаар шийдсэн болно.

[Түлхүүр үг]

Үлдэгдлийг төлөхийг шаардах хамаарал бүхий буюу шалтгаант эрх, үүргийг хүлээн зөвшөөрөх, үүргийн гүйцэтгэл.

I. Оршил

Тооцоо нийлэх гэрээний зохицуулалт нь анх италийн хот улсууд тэр дундаа венецийн банк болон түүний бусад улсын харилцагч, үйлчлүүлэгч нарын хооронд үүссэн заншлын эрх зүйн хэм хэмжээнээс улбаатай гэгддэг¹. Манай улс 2002 онд өдгөө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Иргэний хуулиа батлахдаа анх удаа “тооцоо нийлэх” гэрээний зохицуулалтыг хуульчилжээ. Мэдээж хэрэг анх удаа тухайн зохицуулалтыг боловсруулсан тул нэр томъёо болон агуулгын хувьд ойлгоход төвөгтэй асуудлууд цөөнгүй байсан нь тодорхой. Практикт иргэд болон аж ахуйн нэгжүүд нягтлан бодох бүртгэлийн баримт болох тооцоо нийлсэн акт, тооцооны үлдэгдлийн баталгаа зэргийг үйлдсэн тохиолдолд тооцоо нийлэх гэрээ байгуулагдлаа гэж ойлгох явдал ихээхэн түгээмэл болжээ. Түүнчлэн практикт гүйцэтгээгүй үүргийн гүйцэтгэлийг хожим баталгаажуулах буюу үнийн дүнг нь тодорхойлох зорилгоор төлбөр барагдуулах гэрээ, төлбөр тооцооны гэрээ гэх зэрэг нэр бүхий тохиролцоог бичгээр байгуулах тохиолдол ч цөөнгүй ажиглагдаж байна. Тиймээс талууд тооцоо нийлэх гэрээ байгуулсан эсэхийг үндэслэлтэйгээр тодорхойлох, нөгөөтэйгүүр тооцоо нийлэх гэрээг бусад адил төстэй хэлцлээс ялган тайлбарлах нь эрх зүйн үр дагаврын хувьд өөр хоорондоо ихээхэн ялгаатай эрх зүйн харилцааг зөв танин мэдэх, цаашлаад иргэд болон аж ахуйн нэгжийн эрх ашгийг хамгаалахад маш чухал асуудлын нэг болно. Гэвч одоогийн байдлаар тус гэрээний талаар судалсан эх сурвалж цөөн төдийгүй, шүүхийн практикт тооцоо нийлэх гэрээг харилцан адилгүй байдлаар тайлбарлах, тодорхойлох явдал гарсаар байна. Дээрх нөхцөл байдалд тулгуурлан энэхүү бэсрэг судалгааны өгүүллээр дамжуулан юун түрүүнд шүүхийн зүгээс тооцоо нийлэх гэрээг хэрхэн тодорхойлж, тайлбарлаж байгаа эсэх талаар Улсын Дээд Шүүхийн нэгэн онцлог бүхий тогтоолд үндэслэн судалж, дараагаар нь манай улсын Иргэний хууль дахь тооцоо нийлэх гэрээний зохицуулалтад голлох нөлөөг үзүүлсэн орны холбогдох хэм хэмжээ болон хууль зүйн тайлбарын агуулгыг товч харьцуулан өөрийн зүгээс тодорхой дүгнэлт гаргахыг зорьсон болно. Мэдээж хэрэг тус сэдвийн агуулга өргөн тул энэхүү өгүүллийн хүрээнд зарим үндсэн суурь асуудлыг хөндөж судлахыг хичээлээ.

II. Монгол Улсын Дээд Шүүхийн 2022 оны 02 сарын 22 өдрийн 00176 дугаар тогтоол

Тооцоо нийлэх гэрээтэй холбоотой маргааныг шийдвэрлэсэн Улсын Дээд Шүүхийн тогтоол цөөн гарчээ. Гэвч эдгээр дундаас 2022

¹ 濱田一男、交互計算の法理:比較法的考察、法政研究、40 (1) 1973、37頁。

онд гарсан нэгэн тогтоолын агуулга тус гэрээтэй холбоотой хууль зүйн тайлбарын асуудлыг олон талаас нь эргэцүүлэх боломж олгож байх тул судлаачийн хувьд энэхүү тогтоолд тулгуурлан шүүхийн практик дахь асуудлыг илрүүлэхийг зорьсон болно.

Хэргийн товч агуулга

Нэхэмжлэгч Д.Э нь хариуцагч Т.Б-д 2019 оны 09 сарын 16-ны өдөр 18 000 000 төгрөгийг сарын 8 хувийн хүүтэйгээр 2019 оны 10 сарын 16-ны өдөр төлөх нөхцөлтэйгөөр зээлийн гэрээ байгуулсан байна. Ингэхдээ гэрээгээ нотариатаар гэрчлүүлжээ.

Энэхүү зээлийн гэрээ нь Т.Б нь Д.Э-ийн эхнэр Д.Ч-ээс 2017 болон 2018 онуудад зээлж байсан мөнгөнүүдийн үлдэгдэл бөгөөд тухайн үлдэгдэл мөнгөө төлөх баталгаа болгож тус гэрээг өөрийн нөхөртэйгөө байгуулах саналыг Д.Ч нь Т.Б-д тавьсан байна.

Гэвч Т.Б нь мөнгөө хугацаандаа зохих ёсоор төлөөгүй тул нэхэмжлэгч нь үндсэн зээл болон хүү, алданги нийт 26 000 000 төгрөгийг Т.Б-ээс гаргуулахаар нэхэмжилжээ.

Шүүхийн шийдвэр болон үндэслэлийн агуулга

Гурван шатны шүүх²-ээс талуудын хоорондох эрх зүйн харилцааг яг адил агуулгаар тайлбарлажээ. Шүүхийн шийдвэрийн үндэслэлийг тайлбарлавал юун түрүүнд шүүхээс хариуцагч Т.Б нь нэхэмжлэгч Д.Э-н эхнэр Д.Ч-тэй удаан хугацаанд зээлийн гэрээний харилцаатай байсан бөгөөд 2019 оны 09 сарын 16-ны өдөр байгуулсан зээлийн гэрээний хувьд Т.Б нь Д.Ч-ээс 2017, 2018 онуудад авч байсан зээлийн төлөгдөөгүй үлдэгдэл болохыг Т.Б хүлээн зөвшөөрсөн болохыг үндэслэсэн. Улмаар Т.Б нь 2019 оны 09 сарын 16-ны өдрийн зээлийн гэрээг байгуулсны дараа 18 000 000 төгрөгийг нэхэмжлэгч Д.Э-с хүлээж аваагүй боловч өмнө байсан зээлийн гэрээний үүрэг гэдэгтэй маргаагүй гэж дүгнэсэн байна.

Дээрх нөхцөл байдалд үндэслэн нэхэмжлэгч Д.Э-ын хувьд эхнэр Д.Ч-гийн Т.Б-д зээлдүүлсэн мөнгөн хөрөнгийн үлдэгдлээр тооцоо нийлэх замаар гэрээ байгуулсан байна гэж тайлбарлаад тус гэрээгээр хүү, алданги тогтоосон нь Иргэний хуулийн 466 дугаар зүйлийн 466.2, 466.5 дахь хэсэгт заасанд нийцсэн байна гэж тайлбарлажээ.

Төсөвтэй хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэртэй харьцуулах нь

Орхон аймгийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2021 оны 10 сарын 21-ний өдрийн 87 дугаартай магадлалыг дээрх шүүхийн шийдвэртэй харьцуулан судлах бүрэн боломжтой байна.

² Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 182/ШШ2020/01079 дүгээр шийдвэр, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 1535 дугаар магадлал

Тус магадлалын хувьд нэхэмжлэгч О.Б болон хариуцагч Ч.Э нарын хооронд байгуулагдсан төлбөр барагдуулах гэрээний талаар дүгнэсэн болно. Хэргийн агуулгыг товч танилцуулбал хариуцагч Ч.Э нь өөрийн нөхөр Г.Г-г БНСУ-д явуулахад шаардагдах дансны баталгааны төлбөр болох 5 000 000 төгрөгийг 2017 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр, мөн АНУ-д визний материал бүрдүүлэхэд шаардагдах 3 500 000 төгрөгийг 2018 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр тус тус нэхэмжлэгч О.Б-гээс авсан байна. Талууд эдгээр мөнгө олгосон үйлдлүүд нь зээлийн гэрээ байсан болох талаар маргадаггүй боловч нэхэмжлэгч О.Б-гийн хувьд талууд 2017 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр 5 000 000 төгрөг, 2018 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр 3 500 000 төгрөгийг 3 жилийн хугацаатай, 5 хувийн хүүтэй байхаар тохирч зээлийн гэрээг бичгээр байгуулсан ба хожим тооцоо нийлж төлбөр барагдуулах гэрээ байгуулснаар өмнөх гэрээ хэрэггүй болсон тул өөрт байсан хувийг хариуцагч Ч.Эд өгсөн гэж тайлбарладаг бол Ч.Э нь 2017 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн зээлийн гэрээг 6 хувийн хүүтэй, 3 сарын хугацаатай байхаар тохирч бичгээр байгуулсан. 2018 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн гэрээг бичгээр байгуулаагүй, тохирсон хугацаанд төлбөрөө бүрэн төлж чадаагүй гэж тайлбарладаг.

Хариуцагч Ч.Э нь зээлийн төлбөрийг хугацаандаа бүрэн төлж барагдуулаагүй тул талууд 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн төлбөр барагдуулах гэх нэртэй гэрээг байгуулсан байна. Тус гэрээгээр хариуцагч Ч.Э нь 2017 оны 09 дүгээр сарын 06-ны өдрөөс 2018 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр хүртэл 2 100 000 төгрөг, 2018 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс 2018 оны 03 дугаар сарын 08-ны өдөр хүртэл 420 000 төгрөгийг тус тус төлсөн гэж заасан байна. Нэхэмжлэгч О.Б нь хариуцагчийг 3 740 000 төгрөг /2 100 000+ 420 000+ 1 220 000/-ийг төлсөн буюу тус үнийн дүнгээр үүргээ гүйцэтгэсэн болохыг хүлээн зөвшөөрсөн. Төлбөр барагдуулах гэрээний дагуу хариуцагч Ч.Э нь 10 930 000 төгрөг төлөх үүрэг үлдсэн гэж нэхэмжлэгч О.Б тайлбарладаг.

Анхан шатны шүүхийн зүгээс хариуцагч Ч.Э нь нэхэмжлэгчид 3 740 000 төгрөг төлсөн, мөн ниссан вингрод суудлын автомашиныг 8 500 000 төгрөгт тооцож О.Б-гийн эзэмшилд шилжүүлж өгсөн болохыг тогтоосон бөгөөд нэхэмжлэгч О.Б төлбөр барагдуулах гэрээний дагуу шаардах эрхээ хэрэгжүүлж байгаа гэж тайлбарлах боловч уг гэрээг дүгнэхэд талуудын хооронд байгуулагдсан үндсэн гэрээ буюу зээлийн гэрээний харилцаа чухал ач холбогдолтой юм гээд өөрөөр хэлбэл талуудын хооронд байгуулагдсан гэх зээлийн гэрээгээр ямар хугацаа тохирсон, гэрээний сунгалт тухай бүр хийгдсэн эсэх нь тооцоо нийлэхэд ач холбогдолтой гэж тайлбарлажээ.

Улмаар нэхэмжлэгч нь Иргэний хуулийн 466 дугаар зүйлийн

466.6.-д Тооцоо нийлэх гэрээний дагуу үүссэн шаардлагыг үүргийн гүйцэтгэлийг хангах аль нэг аргаар хангасан бол үүрэг гүйцэтгүүлэгч тооцоо нийлсний дараа ийнхүү хангасан хэмжээгээр тооцооны үлдэгдлийг төлөхийг үүрэг гүйцэтгэгчээс шаардах эрхтэй гэж заасны дагуу шаардах эрх үүссэн гэж байгаа боловч, Иргэний хуулийн 466 дугаар зүйлийн 466.1.-д Тооцоо нийлэх гэрээгээр талууд хоорондын ажил хэргийн харилцаанаас үүссэн шаардлагыг гэрээнд заасан хугацааны дотор харилцан тооцоо нийлэх замаар хаахаар тохиролцох бөгөөд тооцоо нийлэх хүртэл шаардлага гаргахгүй байх үүрэг хүлээнэ гэж заасан ба гэрээнд заасан хугацааны дотор тооцоо нийлсэн эсэх нь тодорхойгүй, зээлийн гэрээнүүд бичгийн хэлбэртэй байгуулагдсан эсэх нь нотлогдохгүй байна гэж дүгнэсэн байна. Тиймээс тус шүүхийн зүгээс хариуцагч Ч.Э нь нэхэмжлэгч О.Бд төлөх төлбөргүй, зээлийн гэрээний дагуу үүргээ гүйцэтгэсэн гэж дүгнээд 10 930 000 төгрөг гаргуулах тухай үндсэн нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

Давж заалдах шатны шүүхийн хувьд нэхэмжлэгч О.Б, хариуцагч Ч.Э нар 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр зохигчдын хооронд өмнө нь байгуулагдсан зээлийн гэрээнд үндэслэн “Төлбөр барагдуулах гэрээ” байгуулсан байх ба тухайн гэрээгээр зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотойгоор гэрээ бүрээр үндсэн зээл, хүүг төлсөн мөнгийг тооцон төлөхөөр тохиролцсон байх боловч хуульд заасан үндэслэлээр байгуулагдаагүй, зээлийн гэрээгээр хүү тооцсон өндөр хүү төлүүлэхээр шийдвэрлэснийг тооцоо нийлэх гэрээ хийгдсэн гэх үндэслэлээр үнэлэн шийдвэрлэх боломжгүй юм гээд Иргэний хуулийн 466 дугаар зүйлд заасан тооцоо нийлэх гэрээ нь гэрээний талуудын хооронд хийгдэх ёстой олон тооны төлбөрийг нэг төлбөр, шаардлага болгон цөөлдөг ба гэрээг талуудын хоорондын ажил хэргийн харилцаанаас үүссэн олон шаардлагыг харилцан тооцоо нийлэх замаар нэг тооцоо гаргаж, нийт дүнг тогтоон ажиллах тухай тохиролцоо юм гэж тайлбарлажээ.

Улмаар зохигчдын хооронд хийгдсэн зээлийн гэрээнүүд бичгээр хийгдэж иргэд хоорондын зээлийн гэрээгээр хүү авах эрх үүссэн эсэх нь төлбөр барагдуулах гэрээг үнэлэхэд ач холбогдолтой учраас зээлийн гэрээгээр хүлээсэн болон гүйцэтгэсэн үүргийг харгалзан үзэж хуульд нийцүүлэн шийдвэрлэх учиртай тул анхан шатны шүүхийн шийдвэрийн нэхэмжлэлийн үндсэн болон сөрөг нэхэмжлэлийн шаардлагын талаар хийсэн дүгнэлтийг үгүйсгэх боломжгүй байна гэж дүгнээд анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж нэхэмжлэгч О.Б, нэхэмжлэгчийн өмгөөлөгч М.Г, М.М нарын гаргасан давж заалдсан гомдлыг хүлээн авах боломжгүй гэж шийджээ.

Дээрх шүүхийн шийдвэр нь тус судалгааны хүрээнд голчлон судлахаар сонгон авсан Монгол Улсын Дээд Шүүхийн 2022 оны 02 сарын 22 өдрийн 00176 дугаар тогтоолтой ихээхэн төстэй. Учир нь зохигч нарын хооронд хоёр удаагийн зээлийн гэрээ байгуулагдсан боловч хариуцагч (зээлдэгч) нь гэрээгээр тохиролцсон төлбөрөө хугацаандаа зохих ёсоор төлөөгүйн улмаас талууд хожим нь нийт үлдэгдэл төлбөрийг тодорхойлж тухайн төлбөртөө хүү (алданги) тогтоосон байгаагаараа төсөөтэй байна. Гэвч Улсын Дээд Шүүхийн зүгээс өмнө зээлийн үлдэгдэл төлбөрийг тодорхойлж дахин үүргээ гүйцэтгэх хугацаа тогтоосон шинээр байгуулсан зээлийн гэрээг “тооцоо нийлэх гэрээ” гэж дүгнэсэн бол тус хэргийн давж заалдах шатны шүүхийн зүгээс зээлийн гэрээний харилцаа ямар дүнгээр үүссэн эсэх нь тодорхой бус байх тул тооцоо нийлэх гэрээ гэж дүгнэх боломжгүй гэж дүгнэжээ. Тиймээс шүүхийн практикт төсөөтэй хэргийн хувьд ч гэсэн харилцан адилгүй байдлаар Иргэний хуулийн зохицуулалтыг тайлбарлан хэрэглэж байна гэж дүгнэх боломжтой байна. Хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах явдалд хойрго хандах нь тухайн эрх зүйн харилцааны оролцогч нарын эрх ашиг, ашиг сонирхолд ихээхэн сөрөг нөлөөтэй болох нь нэгэнт тодорхой болсон асуудал билээ.

Тус өгүүллийн хүрээнд голлон судалж буй Улсын Дээд Шүүхийн тогтоолд дурдсан шиг талууд өмнө байгуулсан зээлийн гэрээний төлөгдөөгүй үлдэгдэл төлбөрийн хувьд дахин шинээр зээлийн гэрээ байгуулах явдал бодит практикт гарах боломжтой. Гэхдээ яг ийм тохиолдолд Иргэний хуулийн 236 дугаар зүйлийн 236.1.3 дахь заалтыг хэрэглэх эсэх асуудал үүсч болно. Ямартай ч шүүхийн практикаас дүгнэвэл зарим тохиолдолд зээлийн гэрээ нь бодит гэрээнд хамаарна гэж тайлбарлаад зээлсэн мөнгөө бодитоор зээлдэгчид шилжүүлээгүй буюу өмнөх зээлийн гэрээний дагуу шилжүүлсэн мөнгө тул үүргийг сольсон хэлцэл байгуулагдахгүй гэж тайлбарлах хандлага бий. Энэ хандлагын дагуу тус Улсын Дээд Шүүхийн тогтоолын шийдвэрийн талаар дүгнэвэл нэхэмжлэгч Д.Э болон хариуцагч Т.Б нарын хооронд 2019 оны 09 сарын 16-ны өдөр байгуулсан зээлийн гэрээ нь огт байгуулагдаагүйд тооцогдох магадлалтай байна. Тиймээс үүргийг солихоор тохиролцох болон тооцоо нийлэх гэрээний харилцан хамаарал болон ялгааг эргэцүүлэх шаардлага үүснэ.

Нөгөөтэйгүүр талууд дахин шинээр зээлийн гэрээ байгуулсан нь зүгээр л өмнөх зээлийн гэрээнүүдэд оруулсан нэмэлт, өөрчлөлт байхыг ч үгүйсгэхгүй. Гэхдээ талуудын хүсэл зориг ямар байдлаар гэрээнд тусгагдсан бэ гэдэг нь үүнийг тодорхойлоход голлох нөлөөтэй. Эсхүл зүгээр л өмнө амаар тохиролцсон байсан тул хожим

өөрсдийн тохиролцоог баталгаажуулах буюу нотлох баримт үлдээх зорилгоор гэрчлэх гэрээ байгуулсан байхыг ч үгүйсгэхгүй.

Бусад холбогдох шүүхийн практик

Дээрх хоёр шийдвэрийн агуулгаас Иргэний хуулийн 466 дугаар зүйлийн талаар шүүхийн зүгээс хэрхэн тайлбарлаж буй болохыг бүрэн дүүрэн тодорхойлох боломжгүй тул зарим холбогдох бусад шүүхийн шийдвэрийн голлох үндэслэл болон тайлбарыг энд танилцуулъя.

Шүүхийн зүгээс Иргэний хуулийн 466 дугаар зүйлийн 466.1 дэх хэсгийн “талууд хоорондын ажил хэргийн харилцаанаас үүссэн” гэх нөхцөлийн талаар “худалдах, худалдан авах гэрээний үнийг төлөх үүргийг гүйцэтгэхтэй холбоотой иргэд хооронд байгуулсан хэлцэл нь Иргэний хуулийн 466 дугаар зүйлийн 466.1 дэх хэсэгт заасан талууд хоорондын ажил хэргийн харилцаанаас үүссэн гэх шинжийг агуулаагүй байна.” гэж³, түүнчлэн “Учир нь Иргэний хуулийн 466 дугаар зүйлийн 466.1 дэх хэсэгт зааснаар тооцоо нийлэх гэрээг талуудын хооронд ажил хэргийн харилцаанаас үүссэн шаардлагыг харилцан тооцоо нийлэх замаар хаахаар тохиролцож, тооцоо нийлэх хүртэл шаардлага гаргахгүй байх үүрэг хүлээдэг байна. Өөрөөр хэлбэл, энэ гэрээний талууд хоорондоо ажил хэргийн буюу бизнесийн харилцаа бүхий аж ахуй эрхлэгчид хийдэг. Иймд хөдөлмөрийн гэрээний дагуу үүссэн харилцаатай холбоотойгоор ажил олгогч болон ажилтны хооронд ажил үүргийн хүрээнд өр авлагын тооцоо хийснийг аж ахуй эрхчлэгч хооронд хийсэн тооцоо нийлэх гэрээний агуулгад хамааруулан дүгнэхгүй.” гэж⁴ тус тус тайлбарласан байна.

Мөн “Зохигчид 2015 оны 08 дугаар сарын 05-ны өдөр өгч авсан зүйлээ санхүүгийн баримтаар нийлж, тооцооны үлдэгдлийн баталгаа гэх баримт үйлдсэнийг Иргэний хуулийн 466 дугаар зүйлийн 466.1-т заасан тооцоо нийлэх гэрээ байгуулагдсан гэж үзэхгүй” гэж⁵, “Иргэний хуулийн 466 дугаар зүйлийн 466.1-д заасан тооцоо нийлэх гэрээний зүйл нь талуудын хооронд ажил хэргийн харилцаанаас үүдсэн шаардлага байх ба аж ахуй эрхлэгч байгууллагын бизнесийн үйл ажиллагааны явцад бий болсон газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх, мөнгөн төлбөр гаргуулах шаардлагын талаар тооцоо нийлсэн нь ажил хэргийн харилцаанаас үүдсэн шаардлага гэх ойлголтод хамаарч болно. Гэвч гэрээний шаардлагын аль нэг хэсгийн тухайд байгууллагын нягтлан бодогчид тооцоо нийлэн санхүүгийн баримт үйлдсэн нь тооцоо нийлээгүй тухайн хэсгийг шаардах эрхээсээ татгалзсан, эсхүл

³ Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал 2023.08.02 №01508

⁴ Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал 2022.11.18 №02006

⁵ Улсын дээд шүүхийн тогтоол 2016.12.01 №01300

энэ эрхийн үндэслэл болсон гэрээний заалтад өөрчлөлт оруулсан гэж үзэхгүй. Өөрөөр хэлбэл, ажлын үндсэн чиг үүргийн дагуу санхүүгийн баримт үйлдсэн үйлдлийг тооцоо нийлэх гэрээ байгуулах замаар талуудын хооронд байгуулсан гэрээг өөрчилсөн гэж дүгнэхгүй.” гэж⁶ тус тус тайлбарлажээ.

Харин тооцоо нийлэх гэрээ болон Иргэний хуулийн 236.1.3 дахь заалтын харилцан хамаарлын талаар “талуудын хооронд байгуулагдсан уг гэрээгээр талууд түрээсийн гэрээний харилцаанаас үүссэн шаардлага, өр төлбөрийн талаар харилцан тооцоо нийлж, уг тооцоонд заагдсан өр төлбөрийг төлөх хугацааг үе шаттайгаар тодорхойлсон байх тул Иргэний хуулийн 466 дугаар зүйлийн 466.1 дэх хэсэгт заасан тооцоо нийлэх гэрээ байгуулагдсан гэж үзэхээр байна.” гээд “гэтэл анхан шатны шүүх талуудыг түрээсийн гэрээний үүргийн харилцааг төлбөр барагдуулах гэрээний үүргийн харилцаагаар сольсон гэж дүгнэсэн нь Иргэний хуулийн 236 дугаар зүйлийн 236.1.3-т нийцээгүй, хууль буруу тайлбарлан хэрэглэсэн байна. Учир нь талууд өмнөх түрээсийн гэрээний үүргээс үүдэлтэй өр төлбөрийн талаар тооцоо нийлж, түүнийгээ баталгаажуулан, төлбөр төлөх хугацааг шинэчлэн тогтоож, уг үүргийг гүйцэтгээгүй тохиолдолд хүлээх хариуцлагаа буюу алданги зэргийг тодорхойлсон бие даасан гэрээг шинээр байгуулсан байна. Иргэний хуулийн 236 дугаар зүйлийн 236.1.3-т заасны дагуу үүргийг өөр үүргээр сольсон тохиолдолд уг үүргийг биелүүлээгүйгээс үүсэх үр дагавар өмнөх буюу түрээсийн гэрээний хүрээнд тодорхойлогдоно. Гэтэл шүүх сүүлд байгуулагдсан, хэрэгт авагдсан төлбөр барагдуулах гэрээний дагуу алдангийг тооцсон атлаа гэрээний үүргийг солигдсон гэж үзсэн нь учир дутагдалтай болжээ.” гэж тайлбарласан байна⁷.

Дээрхээс дүгнэвэл шүүхийн хувьд тооцоо нийлэх гэрээ нь зөвхөн аж ахуй эрхлэгч нарын хооронд л байгуулагдах боломжтой буюу хоёр талын арилжааны хэлцэлд хамаарна гэж тайлбарлах хандлага тодорхой түвшинд хэрэгжиж байгаа болохыг харж болохоор байна. Мөн тооцоо нийлсэн акт гэх зэрэг нягтлан бодох бүртгэлийн баримт нь тус гэрээг байгуулсан болохыг шууд гэрчлэхгүй гэж дүгнэсэн байна. Харин үүргийг солих хэлцэл болон тооцоо нийлэх гэрээний ялгааг тайлбарлахдаа үүргийг солих тохиолдолд өмнөх үүргийн эрх зүйн харилцаа чухамдаа үүргийн зөрчилтэй холбоотой аливаа шаардлага уламжлагдах бол тооцоо нийлэх гэрээ байгуулсан тохиолдолд бие даасан шинэ гэрээ тул өмнөх үүргийн харилцаатай огт хамааралгүй гэх агуулгыг илэрхийлсэн байх юм.

⁶ Улсын дээд шүүхийн тогтоол 2024.02.20 №00035

⁷ Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал 2017.08.16 №1846

Тиймээс ерөнхийлөн дүгнэвэл шүүхийн практикт тооцоо нийлэх гэрээг гэрээний талуудын хооронд хийгдэх ёстой олон тооны төлбөрийг нэг төлбөр, шаардлага болгон цөөлдөг ба гэрээг талуудын хоорондын ажил хэргийн харилцаанаас үүссэн олон шаардлагыг харилцан тооцоо нийлэх замаар нэг тооцоо гаргаж, нийт дүнг тогтоон ажиллах тухай тохиролцоо гэж тайлбарлах хандлага түгээмэл байх бөгөөд ажил хэргийн харилцаа гэдгийг аж ахуй эрхлэгч нарын хоорондын бизнесийн харилцаанаас үүдэлтэй гэх байдлаар тодорхойлж байна. Мөн нийлмэл хүү тооцох явдлыг шүүхээс шууд дүгнээгүй боловч өмнөх зээлийн гэрээний гүйцэтгэгдээгүй үүргийн хувьд дахин хүү тохирох явдлыг зөвшөөрч байх тул нийлмэл хүү тооцохыг хүлээн зөвшөөрсөн практик байгаа гэж дүгнэж болох юм. Гэхдээ алдангийн хувьд бол давхар тооцохыг зөвшөөрөхгүй байгаа нь тодорхой ажиглагдана. Харин тооцоог хааснаар яг ямар эрх зүйн үр дагавар үүсдэг болох, өмнөх шаардах эрх, үүрэг болон тооцоог хаасны дараах шаардах эрх болон үүргийн харилцан хамаарал, үндсэн шинжийн талаар тайлбарласан шүүхийн шийдвэр огт ажиглагдсангүй.

III. Харьцуулалт /ХБНГУ/

Дээрх нөхцөл байдалд тулгуурлан одоогийн Иргэний хуулийн 466 дугаар зүйлийн зохицуулалтад голлох нөлөөг үзүүлсэн ХБНГУ-ын Арилжааны хууль дахь тооцоо нийлэх гэрээний зохицуулалт болон холбогдох хууль зүйн тайлбарын талаар харьцуулан судлахаар шийдвэрлэсэн болно.

Тооцоо нийлэх (Kontokorrent) нь хоёр талын аж ахуйн харилцаанаас үүссэн харилцан бие бие рүүгээ чиглэсэн шаардах эрхийг харилцан тооцож дуусгавар болгох асуудлыг зохицуулдаг⁸. ХБНГУ-ын Арилжааны хуулийн 355-357 дугаар зүйлд хүү тооцох, үүргийн гүйцэтгэлийг хангах арга үргэлжлэх гэх зэрэг хоёрдогч шинжтэй асуудлын талаар зохицуулсан байдаг бөгөөд хэрхэн тооцоог нийлэх, харилцан тооцох буюу балансыг үүсгэх эсэх талаар тодорхой зохицуулсан агуулга хуульчлагдаагүй бөгөөд ихэвчлэн талуудын тохиролцооны дагуу тодорхойлогдоно⁹.

ХБНГУ-ын Арилжааны эрх зүйн сурах бичгүүдийг үзвэл ямартай ч тус улсын хувьд тооцоо нийлэх, харилцан тооцох буюу баланс үүсгэх бүтэц, дарааллын талаар хоёр үндсэн аргыг нийтлэг байдлаар хүлээн зөвшөөрсөн гэж дүгнэж болохоор байна. Эхнийх нь тодорхой хугацааны арга (periodenkontokorrent), удаах нь үргэлжилсэн тооцооны арга (staffelkontokorrent) болно. Эхний аргын хувьд тооцоо нийлэх, харилцан тооцох буюу баланс үүсгэх үеийг

⁸ Roth Weller, Handels- und Gesellschaftsrecht, 7. Aufl., Vahlen, 2010, S.344

⁹ Мөн тэнд

тодорхой хугацааны үндсэн дээр тогтоох арга бөгөөд жишээ нь хуанлийн жилийн төгсгөлд, 6 дугаар сарын 10-нд гэх мэт байдлаар тодорхойлно гэсэн үг. Өөрөөр хэлбэл улирал бүрийн төгсгөлд балансаа тооцож гаргах гэх мэт байдлаар талууд тохиролцвол энэ нь тодорхой хугацааны аргад тооцогдоно гэсэн үг. Удаах аргын хувьд нэлээд энгийн аргад тооцогдоно. Жишээ нь нэг тал нь нөгөө талдаа 1500 ам.доллар төлөх үүрэг хүлээсэн бол тэрээр 500 ам.долларыг 1 сарын 20-нд нөгөө талдаа төлмөгц баланс үүсэж явна гэсэн үг. Тиймээс одоо 1000 ам.доллар төлөх үүрэг үлдэнэ. Дараагаар нь 200 ам.доллар зээлсэн бол төлөх ёстой үүрэг нь 1200 ам.доллар болно гэх мэт. Өөрөөр хэлбэл шаардах эрх бүрийг тэр дор тооцож үлдэгдлийг буюу балансыг гаргах арга болно¹⁰.

ХБНГУ-ын Арилжааны хуулийн 355 дугаар зүйлд “Арилжаа эрхлэгчтэй ажил хэргийн харилцаатай тохиолдолд тухайн ажил хэргийн харилцаанаас талуудад харилцан үүссэн шаардах эрх болон үүргийг хүүгийн хамт тооцож, тогтмол хугацаанд харилцан тооцож аль нэг талд үүссэн үлдэгдэл төлбөрийг тодорхойлох замаар тухайн тооцоог хаахаар талууд тохиролцсон бол тооцоог хаасны дараа үүссэн үлдэгдэл төлбөрийг хүлээн авах эрхтэй этгээд нь тухайн тооцоонд хүү тооцогдсон байсан ч хаасан өдрөөс эхлэн үлдэгдэл төлбөрийн хүүг шаардах эрхтэй.” гэж зохицуулсан байна. Өөрөөр хэлбэл тус гэрээний нэг тал нь заавал арилжаа эрхлэгч байх шаардлагатай гэсэн үг¹¹. Мөн харилцан үүссэн шаардах эрх болон үүргийг хүүгийн хамт тухайн тооцоонд хамааруулах боломжтой аж¹².

Тооцоо нийлэх гэрээний хувьд хамгийн чухал анхаарал хандуулах ёстой асуудал нь тухайн талуудын хооронд тооцоо нийлэх гэрээ байгуулагдсан эсэх гэхээсээ илүүтэй тухайн нэг тодорхой шаардах эрхийг тооцоо нийлэх гэрээнд хамааруулсан эсэх явдал болно¹³. Тооцоо нийлэх гэрээ нь өндөр түвшний хийсвэрлэлийн үр дүнд бий болсон ойлголт бөгөөд дөрвөн ялгаатай гэрээнээс бүрэлддэг гэж тодорхойлж болно¹⁴. Үүнд:

- Нэгдүгээрт Kontokorrentabrede буюу тооцоо нийлэх тохиролцоо хийгдсэн байх шаардлагатай. Талуудад харилцан үүссэн шаардах эрх болон үүргийг тооцоо нийлэх гэрээнд хамааруулсан байх;

- Хоёрдугаарт ижил дүн бүхий шаардах эрх болон үүргийг

¹⁰ Мөн тэнд

¹¹ Peter Kindler, Grundkurs Handels- und Gesellschaftsrecht, Verlag C.H. Beck, 2009, S.145

¹² Мөн тэнд

¹³ Мөн тэнд

¹⁴ Мөн тэнд

Verrechnung¹⁵ буюу харилцан тооцох талаар тохиролцсон байх;

- Гуравдугаарт гэрээний талуудад үүссэн үлдэгдлийг тодорхойлох талаар тохиролцсон байх;

- Дөрөвдүгээрт дээрх гурван гэрээний тохиролцоог цогцоор зохицуулсан Rahmenvereinbarung буюу ерөнхий гэрээг байгуулсан байх гэсэн шаардлага тавигддаг байна.

Эндээс харьцуулан үзвэл манай улсын шүүхийн практикийн хувьд талуудад харилцан үүссэн шаардах эрх болон үүрэг гэх агуулгаар бус зөвхөн нэг талын шаардах эрхийн хувьд ч гэсэн тооцоо нийлэх гэрээг байгуулах боломжтой гэсэн тайлбарыг хийж байгаа нь ажиглагдаж байна. Түүнчлэн тооцоо нийлэх гэрээг хийсвэрлэх байдлаар үндсэн бүтцийг зөв тодорхойлох нь ихээхэн чухал болох нь эндээс тодорхой харагдаж байна. Гэвч одоо өөр нэг чухал хууль зүйн тайлбарын асуудал бол аливаа нэг шаардах эрх болон үүргийг тооцоо нийлэх гэрээнд хамааруулснаар ямар эрх зүйн үр дагавар үүсэх вэ гэдэгт харьцуулсан эрх зүйн үүднээс хариулт олох явдал болно.

ХБНГУ-ын хувьд тооцоо нийлэх гэрээнд аливаа нэг шаардах эрх болон үүргийг хамааруулснаар тухайн шаардах эрх болон үүрэг нь өөрийн бие даасан байдлыг алдах эрх зүйн үр дагавар үүснэ гэж тайлбарладаг¹⁶. Энэ нь талууд тодорхой хугацааны аргыг ашигласан тохиолдолд ч гэсэн адил бөгөөд харилцан тооцож баланс үүсгэхээс өмнөх хугацаанд ч гэсэн бие даасан байдлаа алдана гэж үздэг байна¹⁷. Үүнийг Kontokorrentbindung гэх ойлголттой холбож тайлбарладаг бөгөөд энэ нь тооцоо нийлэх гэрээнд шаардах эрхийг хамааруулах гэх агуулгыг илтгэнэ. Шинжлэх ухааны олонд үнэлэгдсэн тайлбарт дурдсанаар бол аливаа шаардах эрхийн хувьд тооцоо нийлэх гэрээний хамаарал үүссэн бол тухайн шаардах эрхийг хэрэгжүүлэх боломжгүй буюу хариуцагч талаас Kontokorrenteinrede буюу тооцоо нийлэх гэрээний хамааралт байдалд суурилсан үүрэг гүйцэтгэхээс татгалзах эрхийг хэрэгжүүлэх боломж үүсдэг байна¹⁸. Судлаачдын хувьд тус үүрэг гүйцэтгэхээс татгалзах эрхийг тооцоо нийлэх гэрээний агуулга болон зорилгод тулгуурлан тайлбарлах замаар хүлээн зөвшөөрөгдсөн эрх гэж үздэг аж¹⁹.

¹⁵ Энэхүү нэр томъёо нь Aufrechnung буюу “харилцан шаардлага бүхий үүргийг тооцож дуусгавар болгох” ойлголтоос ялгаатай нэр томъёо болохыг зайлшгүй анхаарах шаардлагатай. Учир нь зарим онолын хандлагын хүрээнд Verrechnung нь хоёр талын шаардах эрх, үүргийг тооцож үлдэгдлийг л тодорхойлох үйл явц бөгөөд эрх зүйн үр дагавар нь үүргийг дуусгавар болгохтой шууд холбогдохгүй гэж үздэг аж.

¹⁶ Roth Weller, 2010, S.344

¹⁷ Мөн тэнд

¹⁸ Baumbach/Hopt, Handelsgesetzbuch, 33.Aufl.,2008, C.H.Beck, §355, Rn.7.

¹⁹ Canaris, Handelsrecht, 24. Aufl.,2006, §25 Rn.7.

Мэдээж хэрэг тус үүрэг гүйцэтгэхээс татгалзах эрхийг хүлээн зөвшөөрснөөр ХБНГУ-ын Иргэний хуулийн 205 дугаар зүйлд заасны дагуу холбогдох хөөн хэлэлцэх хугацаа нь түр зогсох үр дагавартай төдийгүй нэгэнт л Kontokorrentbindung бий болсон бол тухайн шаардах эрхийг бусдад шилжүүлэх, барьцаалахыг хориглодог байна²⁰. Мөн ХБНГУ-ын Арилжааны хуулийн 355 дугаар зүйлийн агуулгаас дүгнэвэл тооцоо нийлэх гэрээний хувьд ХБНГУ-ын Иргэний хуулийн 248 дугаар зүйлийн 248.1 дэх хэсгийн зохицуулалт үйлчлэхгүй болох нь тодорхой харагдана²¹. Учир нь тооцоо нийлэх гэрээнд шаардах эрх, үүрэг болон хүүг хамааруулах боломжтой бөгөөд түүнээс дахин хүү тооцох боломжтой болохыг хуульчилсан байна.

Түүнчлэн аливаа шаардах эрх нь тооцоо нийлэх гэрээнд хамаарснаар “харилцан тооцох”-той холбоотой үндсэн хоёр эрх зүйн үр дагавар үүснэ гэж тайлбарладаг²². Үүнд

Шаардах эрх болон үүргийг харилцан тооцооноор (Verrechnung) “харилцан шаардлага бүхий үүргийг тооцож дуусгавар болгох (Aufrechnung)”-той адил эрх зүйн үр дагавар үүсэх буюу тухайн шаардах эрх, үүрэг нь дуусгавар болно. Тиймээс харилцан тооцох (Verrechnung) нь үүргийн гүйцэтгэл (Tilgung)-тэй адил эрх зүйн үр дагавартай гэсэн үг²³. Харилцан тооцооноор үлдэгдлийг шаардах эрхтэй талд “үлдэгдлийг төлөхийг шаардах (хамаарал бүхий) эрх²⁴ (kausale Saldoforderung)” үүсэх бөгөөд тус эрхийг хэрэгжүүлэхэд тухайн шаардах эрхтэй тал ямар нэгэн хүсэл зоригоо илэрхийлэх нэмэлт шаардлага тавигддаггүй. Учир нь тооцоо нийлэх гэрээнд харилцан тооцох гэрээ (Verrechnungsvertrag) багтсан байдаг.

Гэвч харилцан тооцох бүтэцтэй холбоотойгоор хоёр өөр хандлага сөргөлддөг гэж болно. Нэгдүгээрт gesamtaufrechnung буюу ерөнхийлөн тооцох хандлага байх бөгөөд энэ хандлагаар бол шаардах эрхүүд өөр хоорондоо харилцан пропорциональ байдлаар тооцогдоно гэсэн үг. Жишээ нь нэг тал нь 15000 ам.долларын 3 шаардах эрхтэй, эсрэг тал нь 6000 ам.долларын нэг шаардах эрхтэй бол тухайн 6000 ам.долларын шаардах эрх нь пропорциональ байдлаар буюу гурван шаардах эрхээс тус бүр 2000 ам.доллар хасагдах байдлаар тооцогдоно

²⁰ Peter Kindler, 2009, S.147

²¹ Мөн тэнд

²² Canaris, 2006, §25 Rn.16.

²³ Хэрвээ харилцан тооцсон ч гэсэн өөр нэмэлт эрх зүйн үйлдэл шаардагдаж байж шаардах эрх болон үүрэг дуусгавар болно гэж тайлбарлавал үүргийн гүйцэтгэлийн чиг үүргийг гүйцэтгэх боломжгүй нь мэдээж. Ийм хууль зүйн тайлбар мөн байгаа болохыг энд онцлон тэмдэглэх нь зүйтэй. Холбогдуулан BGHZ 93, 307, 313-г үзнэ үү.

²⁴ Ё.Каюг нар, Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар, УБ.,2010 он, 906 дахь талд “үлдэгдлийг төлөхийг шаардах эрх” гэх байдлаар оноон ашиглажээ.

гэж тайлбарладаг байна²⁵. Үүнийг үгүйсгэдэг хандлагын хувьд бол үүргийн гүйцэтгэлийн талаарх ерөнхий зохицуулалт болох ХБНГУ-ын Иргэний хуулийн 366, 367, 396 дугаар зүйлийг хэрэглэх байдлаар харилцан тооцох шаардлагатай гэж тайлбарладаг бөгөөд өөрөөр хэлбэл үүрэг гүйцэтгэх дарааллын зохицуулалтыг баримтлах нь зохистой гэж үздэг байна²⁶.

Өмнө дурдсан “үлдэгдлийг төлөхийг шаардах хамаарал бүхий буюу шалтгаант эрх (kausale Saldoforderung)” үүссэн тохиолдолд тус шаардах эрх нь тооцоо нийлэх гэрээнд хамааруулсан өмнөх шаардах эрх болон үүрэгтэй хамаарал бүхий (шалтгаант) байх тул шаардах эрхээ хэрэгжүүлэхийн тулд талуудын хооронд үүссэн өмнөх шаардах эрх болон үүргийг нотлох шаардлага үүснэ гэсэн үг. Мэдээж хэрэг энэ нь ихээхэн төвөгтэй нотлох үйл ажиллагааг дамжин хэрэгжих нь тодорхой. Харин харилцан тооцсоны дараах үлдэгдлийг талууд тодорхойлж түүнийг хүлээн зөвшөөрснөөр *abstrakte Saldoforderung* буюу үлдэгдлийг төлөхийг шаардах үл хамаарал бүхий буюу хийсвэр эрх үүсэх боломжтой. Үүнийг хууль зүйн талаас нь ХБНГУ-ын судлаачид болон хуульчид тайлбарлахдаа Иргэний хуулийн 781 дүгээр зүйлд заасан үүргийг хүлээн зөвшөөрөх²⁷ тохиолдол гэж тодорхойлох явдал түгээмэл байдаг ажээ²⁸. Тус зохицуулалтын агуулгыг дор хөрвүүлбэл:

781 дүгээр зүйл. Үүргийг хүлээн зөвшөөрөх

Тодорхой үүргийн харилцаа үүссэн болохыг хүлээн зөвшөөрөх гэрээ (үүргийг хүлээн зөвшөөрөх) нь хүлээн зөвшөөрсөн хүсэл зоригийн илэрхийллийг бичгийн хэлбэрээр илэрхийлсэн тохиолдолд хүчин төгөлдөр байна. Цахим хэлбэрээр хүлээн зөвшөөрсөн хүсэл зоригийг илэрхийлэхгүй. Үүргийн харилцааг хүлээн зөвшөөрөх тохиолдолд энэ талаар өөр хэлбэрийн шаардлага хуульчлагдсан бол тухайн хэлбэрийн дагуу үүргийг хүлээн зөвшөөрсөн гэрээг байгуулах шаардлагатай. Тус 781 дүгээр зүйлийн зохицуулалт нь ямар нэгэн шалтгаант хэлцэлгүйгээр, тухайн шалтгаант хэлцэл²⁹ нь хүчин төгөлдөр эсэхийг харгалзахгүйгээр үүргийг хүлээн зөвшөөрөх

²⁵ BGHZ 49, 24, 30

²⁶ Canaris, 2006, §25 Rn.23; RGZ 56, 19; RGZ 132, 218

²⁷ Б.Буянхишиг, ХБНГУ-ын Иргэний хууль (кодификацийн бүрэн эх) анхны хэвлэл, УБ.,2017 он, 208 дахь талд “Өр хүлээн зөвшөөрөх” гэж хөрвүүлсэн болохыг харьцуулан үзнэ үү. Жишээ нь Иргэний хуулийн 124 дүгээр зүйлд өр гэх нэр томъёог ашигласан нь бий. Үүнтэй адил байдлаар ашиглажээ. *Schulübernahme* гэх ойлголтын *schuld* гэх ойлголтыг өр гэж буулгасан гэсэн үг. Ер нь *schuld* гэдгийг үүрэг гэж, *schuldrecht* гэдгийг үүргийн эрх зүй гэж буулгах явдал түгээмэл болжээ.

²⁸ BGHZ 93, 307, 313

²⁹ Б.Тэмүүлэн, Д.Энхзул, Б.Буянхишиг, Иргэний эрх зүй ерөнхий анги (анхны хэвлэл), УБ.,2010 он, 45 дахь талд “шалтгаант хэлцэл”, “хийсвэр хэлцэл” гэх ойлголтыг тайлбарласан.

замаар үүргийн харилцааг үүсгэхийг хүлээн зөвшөөрсөн тохиолдол болно хэмээн тайлбарлагддаг байна³⁰. Өөрөөр хэлбэл конститутив эрх зүйн үр дагавар бүхий үүргийг хүлээн зөвшөөрөх хэлцэл нь хийсвэр хэлцэлд хамаарах боломжтой гэсэн үг. Тийм ч учраас ХБНГУ-ын судлаачид үлдэгдлийг төлөхийг шаардах хамаарал бүхий буюу шалтгаант эрхийг “Novatio” буюу үүргийг өөр үүргээр солих замаар үлдэгдлийг төлөхийг шаардах үл хамаарал бүхий буюу хийсвэр эрх рүү шилжүүлэх боломжтой гэж онолын хувьд дээрх тогтолцоог зөвтгөхийг оролддог аж. Гэвч тус онолын тайлбар нь ХБНГУ-ын Иргэний хуулийн 364 дүгээр зүйлийн 364.2 дахь хэсэг болон Арилжааны хуулийн 356 дугаар зүйлийн зохицуулалттай хамтатган тайлбарлахад төдийлөн хангалттай үндэслэлийг дэвшүүлж чаддаггүй гэж шүүмжлэгддэг байна³¹. Үүнийг quasi-novatio гэх мэт бусад оронд ашиглагддаг онолын тайлбарыг ашиглан зөвтгөх үү, эсхүл зүгээр үндсэн зарчмаас гажих тусгайлсан тохиолдол гэж тайлбарлах уу гэх мэт олон онолын асуудал одоо ч бүрэн шийдэгдээгүй төдийгүй тус өгүүллийн хүрээ хязгаартай тул судлаач миний хувьд ч гэсэн эдгээр онолын үлдсэн асуудлыг дараачийн судалгааны хүрээнд танилцуулах боломж олдох болов уу хэмээн найдаж байна.

IV. Дүгнэлт

Энэхүү судалгаагаар Монгол Улсын Иргэний хууль дахь тооцоо нийлэх гэрээний зохицуулалтын талаар шүүхийн практик болон ХБНГУ-ын зохицуулалт, онолын тайлбартай товч харьцуулалт хийх замаар судалж тодорхой санал дэвшүүлэхийг зорьсон.

Тус өгүүллээр голчлон судлахаар зорьсон Монгол Улсын Дээд Шүүхийн 2022 оны 02 сарын 22 өдрийн 00176 дугаар тогтоолын хувьд талууд өмнө байгуулсан хоёр зээлийн гэрээний дагуу үүрэг гүйцэтгэгч төлөх ёстой боловч зохих ёсоор гүйцэтгээгүй үүргийн дүнгээр дахин хүүтэй зээлийн гэрээ байгуулахаар тохиролцсоныг тооцоо нийлэх гэрээ гэж тодорхойлсон байна. Гэвч тус шүүхийн шийдвэрээс дараах асуулт үүснэ. Зээлийн гэрээний гол нөхцөл болон тооцоо нийлэх гэрээний гол нөхцөл ямар ч ялгаагүй юу. Мэдээж хариулт нь үгүй. Зээлийн гэрээгээр зээлдүүлэгч нь зээлдэгчийн өмчлөлд мөнгө шилжүүлэх, зээлдэгч нь мөнгийг тохирсон хугацаанд буцаан өгөх, хүү тохирсон бол хүү төлөх үүргийг тус тус хүлээдэг бөгөөд тус үндсэн үүргийн агуулгаар зээлийн гэрээний гол нөхцөл тодорхойлогдоно. Харин тооцоо нийлэх гэрээний хувьд хэд хэдэн гэрээний цогц байх бөгөөд хэн нэгний өмчлөлд мөнгө шилжүүлэх,

³⁰ Klaus Schreiber, Schuldversprechen und Schuldanerkennntnis, JURA 2014 (1) De gruyter, S.28

³¹ Peter Kindler, 2009, S.148

нөгөө тал нь авсан мөнгөө тохирсон хугацаанд нь буцаан өгөх агуулга огт агуулагдахгүй. Өмнө нь байгуулсан зээлийн гэрээний дагуу үүссэн шаардах эрх болон үүргээ нөгөө талын өөр нэг шаардах эрх болон үүрэгтэй харилцан тооцох талаар л тохиролцоно.

Харин тус шүүхийн шийдвэрт дурдсан тохиролцооны хувьд өмнөх зээлийн гэрээний үүргийг өөр зээлийн гэрээний үүргээр солихоор талууд тохиролцсон байхыг үгүйсгэхгүй. Гэвч энэ тохиолдолд шүүхийн практикт харилцан адилгүй тайлбарын хандлагууд ажиглагдана. Зарим тохиолдолд өмнөх зээлийн гэрээний үлдэгдэл болохоос биш зээлдүүлэгч шинээр байгуулсан зээлийн гэрээний дагуу тохиролцсон мөнгийг зээлдэгчид шилжүүлээгүй байх тул зээлдүүлсэн гэж үзэж хүү шаардах эрх олгох нь зохисгүй³² гэж тайлбарлан үгүйсгэж байгаа бол зарим тохиолдолд өмнөх гэрээний үлдэгдэл төлбөрийн хувьд зээлийн гэрээ байгуулж болно³³ гэж тайлбарлаж байх жишээтэй. Энэ нь зээлийн гэрээг консенсуал гэрээ гэж үзэх үү, эсхүл бодит гэрээ гэж үзэх үү гэсэн хууль зүйн тайлбарын асуудалтай шууд холбогдоно. Энэ талаар шүүхийн зүгээс хангалттай тайлбар хийгээгүй байна.

Тэгвэл энэ тохиолдолд зээлийн гэрээг тооцоо нийлэх гэрээ гэж тайлбарласнаар ямар сөрөг үр дагавар үүсэх вэ гэсэн асуулт мөн адил үүснэ. Харьцуулсан эрх зүйн судалгааны хэсэгт дурдсанчлан тооцоо нийлэх гэрээг талууд байгуулснаар ямар шаардах эрх, үүргийг тус гэрээнд хамааруулах болохыг тодорхойлох шаардлага үүснэ. Тухайн хамааруулсан шаардах эрх, үүргийн хувьд бие даасан байдлаа алдах бөгөөд хөөн хэлэлцэх хугацаа түр зогсох эрх зүйн үр дагавартай. Нөгөөтэйгүүр талууд үлдэгдлийг тодорхойлох буюу баланс үүсгэх тохиолдолд ямар эрх зүйн үр дагавар үүсэх талаар харилцан адилгүй байр суурь байх бөгөөд шууд үүргийг харилцан тооцож дуусгавар болгосонтой адил үр дагавар үүсэх үү, эсхүл талуудын аль нэг нь тооцоог хүлээн зөвшөөрөх тухай гэрээний саналыг нөгөө талдаа гаргаж эсрэг тал түүнийг хүлээн зөвшөөрснөөр сая дуусгавар болох уу гэсэн сонголт үүсдэг. Онолын тайлбарын хувьд нийтлэг байдлаар эхний хувилбарыг дэмждэг.

Мөн эхлээд тооцоог хааснаар “үлдэгдлийг төлөхийг шаардах хамаарал бүхий буюу шалтгаант эрх (kausale Saldoforderung)” үүсэх бөгөөд энэ тохиолдолд тооцоонд хамааруулсан бүхий л шаардах эрх, үүргийн талаар талууд санал зөрсөн тохиолдолд нэг бүрчлэн нотлох хэрэгцээ шаардлага үүсдэг бол ХБНГУ-ын Иргэний хуулийн

³² Нийслэлийн Иргэний Хэргийн Давж Заалдах Шатны Шүүхийн Магадлал, 2022 оны 03 сарын 23-ны өдөр, №00550

³³ Нийслэлийн Иргэний Хэргийн Давж Заалдах Шатны Шүүхийн Магадлал, 2023 оны 08 сарын 09-ний өдөр, №01572

781 дүгээр зүйлд заасан хийсвэр хэлцлийг байгуулах замаар үлдэгдлийг төлөхийг шаардах үл хамаарал бүхий буюу хийсвэр эрх үүсэх боломжтойг ХБНГУ-д хүлээн зөвшөөрсөн байдаг байна. Энэ нь үүргийг өөр үүргээр солих буюу Novatio-той адил эрх зүйн үр дагавартай гэж тайлбарлах хандлага түгээмэл байдаг аж.

Тиймээс талууд зээлийн гэрээ байгуулсан тохиолдлыг тооцоо нийлэх гэрээ гэж тайлбарласнаар талууд яг ямар шаардах эрх, үүргийг тооцоонд хамааруулсан болохыг тодорхойлох боломжгүйн дээр яг хэзээнээс тухайн тооцоонд хамааруулсан шаардах эрх, үүргийн бие даасан байдал алдагдсан болохыг нарийвчлан тогтоох боломжгүй нөхцөл байдал үүсэх болно. Энэ нь бодит байдал дээр талууд тооцооллын хувьд алдсан, өмнөх гэрээний агуулгын талаар буруу ойлгосон, нэг тал нь нөгөө талдаа ашиггүй нөхцөлийг санал болгосон гэх зэрэг тохиолдолд мэдээлэл, мэдлэг, туршлага дутмаг буюу сул дорой талын эрх ашгийг ноцтойгоор хохироох боломжийг бий болгох эрсдэлтэй. Иймд Иргэний хуулийн 199 дүгээр зүйлийн дагуу нэгэнт үүссэн үүргийн харилцааг гэрчлэх гэрээг талууд байгуулж, талуудын хооронд байгуулагдсан өмнөх гэрээний харилцааны агуулгыг бүрэн тодорхойлох боломжтой болсон тохиолдолд л сая тооцоо нийлэх гэрээнд хамааруулсан эсэхийг шийдвэрлэх нь зохистой. Өөрөөр хэлбэл нэг тал нь тодорхой үнийн дүн бүхий мөнгө авсан болохоо шүүхийн шатанд хүлээн зөвшөөрсөн тайлбар гаргасан гэдэг ганцхан шалтгаанаар хоёр талын хооронд гэрээний эрх зүйн харилцаа үүссэн болохыг шууд хүлээн зөвшөөрөх нь учир дутагдалтай юм. Тиймээс тооцоо нийлэх гэрээг бусад гэрээнээс зөв ялгаж хэрэглэх нь онолын төдийгүй практикийн хувьд ч өндөр ач холбогдолтой асуудал болно гэдгийг энд онцолмоор байна.

Дараагаар нь судалгааны хүрээнд авч үзсэн тооцоо нийлэх гэрээтэй холбоотой шүүхийн практикийг нэгтгэн дүгнэвэл манай улсын хувьд шүүхийн зүгээс Иргэний хуулийн 466 дугаар зүйлийн 466.1 дэх хэсгийн “ажил хэргийн харилцаанаас үүссэн шаардлага” гэх ойлголтыг зөвхөн аж ахуй эрхлэгч нарын хоорондын харилцаа гэж тайлбарлах хандлага цөөнгүй ажиглагдаж байлаа. Түүнчлэн өмнө дурдсанчлан зээлийн гэрээ байгуулсан байхад Иргэний хуулийн 198 дугаар зүйлийн 198.1 дэх хэсэгт заасанчлан “гэрээг тайлбарлахдаа түүний үгийн шууд утгыг анхаарна” гэсэн үндсэн зарчмыг үл харгалзан тооцоо нийлэх гэрээ гэж тайлбарлах, түрээсийн гэрээний төлбөр төлөх хугацааг шинэчлэн тогтоосон байхад түүнийг тооцоо нийлэх гэрээ гэж дүгнэсэн байх гэх зэрэг нөхцөл байдал мөн ажиглагдсан болно.

Ер нь тооцоо нийлэх гэрээг зөвхөн аж ахуй эрхлэгч нарын

хооронд байгуулагддаг гэдэг байдлаар явцууруулан тайлбарлавал энэ нь бодит практиктэй үл нийцнэ. Учир нь банк болон харилцагч нарын хооронд тооцоо нийлэх гэрээ ихэвчлэн байгуулагддаг. Тиймээс цаашид тус ажил хэргийн харилцаа гэх ойлголтыг арилжааны эрх зүйн суурь нэр томъёотой холбож шинэчлэх нь зохистой болов уу. Манай улсын хувьд одоогоор шүүхийн практикт хэвшүүлэн хэрэглэх буюу шүүхийн жишгийг зохистой, үр дүнтэй байдлаар хэрэглэх соёл төлөвшөөгүй байгааг энд зайлшгүй харгалзан үзэх нь зүйтэй. Нөгөөтэйгүүр шүүхийн практикт Иргэний хуулийн 236 дугаар зүйлийн 236.1.3 дахь хэсэг буюу талууд өмнөх үүргийг солихоор тохиролцох тохиолдол болон тооцоо нийлэх гэрээний эрх зүйн үр дагаврыг зөв тайлбарлан хэрэглэх асуудал ихээхэн анхаарал татаж байна. Шүүхийн тайлбарыг үзвэл эхний тохиолдолд өмнөх үүргийн эрх зүйн харилцаа уламжлагдах бол удаах тохиолдолд шинэ гэрээ байгуулагдаж байх тул өмнөх үүргийн харилцаатай огт хамааралгүй шинэ үүргийн харилцаа үүснэ гэж үзэж байгаа нь тодорхой харагдана. Гэвч энэ мэт тайлбарыг Иргэний хуулийн 236 дугаар зүйлийн 236.2 дахь хэсэг болон 466 дугаар зүйлийн 466.6 дахь хэсгийн агуулгатай хэрхэн холбож тайлбарлах вэ гэсэн дараачийн төвөгтэй асуудал биднийг угтан авах болно.

Бусад орны тайлбарыг авч үзвэл өмнөх үүргийг солих тохиолдолд өмнөх үүрэг дуусгавар болж, шинэ үүрэг үүсэх бөгөөд өмнөх үүргийн гүйцэтгэлийг хангах аргын хувьд ч гэсэн нэгэн адил дуусгавар болно гэж тайлбарлаж байх бол манайд эсрэг байдлаар тайлбарлаж байгаа нь ажиглагдана. Тиймээс энэ практикийг зайлшгүй шийдвэрлэх шаардлага үүссэн байна. Угтаа бол Иргэний хуулийн 236.2-т энэ талаар тодорхой хуульчилсан. Харин тооцоо нийлэх гэрээний хувьд түүний эрх зүйн үр дагаврын талаар ХБНГУ-тай харьцуулан судлахад уг гэрээг талууд байгуулмагц шууд өмнөх гэрээний харилцаа дуусгавар болохгүй бөгөөд үлдэгдлийг төлөхийг шаардах эрх нь шалтгаант эрх гэж тооцогддог болохыг өмнө дэлгэрэнгүй тайлбарласан билээ. Хамгийн сонирхолтой нь манай шүүхийн практикт тооцоо нийлэх гэрээ байгуулснаар шинэ үүргийн харилцаа үүснэ гэж тайлбарлаж байх боловч шүүхийн шийдвэрүүдэд өмнө байгуулсан гэрээний хүчин төгөлдөр байдал чухал нөлөөтэй болохыг дурдах нь нийтлэг байх юм. Өөрөөр хэлбэл өөр хоорондоо зөрчилтэй тайлбар, үндэслэл цөөнгүй ажиглагдаж байна. Тиймээс тооцоо нийлэх гэрээ байгуулсны эрх зүйн үр дагаврын талаар нэгдмэл практик бий болгох нь ихээхэн чухал асуудлын нэг болжээ.

Судалгааны хүрээнд авч үзсэн асуудлын хувьд дүгнэвэл юун түрүүнд манай улсын хувьд тооцоо нийлэх гэрээний хүрээнд ХБНГУ-

тай адилаар тодорхой хугацааны аргаас гадна үргэлжилсэн тооцооны аргыг ашиглах эсэхийг шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай байна. 466 дугаар зүйлд шууд хориглосон агуулга байхгүй тул миний хувьд үргэлжилсэн тооцооны аргыг ч ашиглах боломжтой гэж үзэж байна.

Харин харилцан тооцох бүтцийн хувьд *gesamtaufrechnung* буюу ерөнхийлөн тооцох хандлагыг хэрэглэх үү, эсхүл үүргийн эрх зүйн ерөнхий ангийн үүргийн гүйцэтгэлтэй холбоотой ерөнхий зохицуулалтыг хэрэглэх үү гэсэн асуулт үүсэх бөгөөд *verrechnung* буюу хоёр талын шаардах эрх, үүргийг тооцож үлдэгдлийг тодорхойлох үйлдэл нь өөрөө үүргийн гүйцэтгэл (*tilgung*)-тэй адил байдлаар тодорхойлогдох боломжтой гэж тайлбарласан тохиолдолд ерөнхийлөн тооцох хандлага бус удаах хандлагыг баримтлах нь системийн тайлбарын хувьд илүү оновчтой, зөрчилдөөнгүй хувилбар болно гэж миний зүгээс үзэж байна. Тийм ч учраас аль нэг тал нь үлдэгдлийг тооцож тухайн тооцооллыг хүлээн зөвшөөрөх тухай гэрээний саналыг нөгөө талдаа гаргаж, нөгөө тал нь хүлээн зөвшөөрсөн тохиолдолд л үүрэг дуусгавар болох эрх зүйн үр дагаврыг хүлээн зөвшөөрөх нь илүү зохистой. Гэхдээ тооцоо нийлэх гэрээнд шаардах эрх, үүргийг хамааруулснаар *kontokorrenteinrede* буюу тооцоо нийлэх гэрээний хамааралт байдалд суурилсан үүрэг гүйцэтгэхээс татгалзах эрх бий болох нь зайлшгүй бөгөөд харин энэ тохиолдолд тухайн шаардах эрхийн хөөн хэлэлцэх нь хугацаа нь Монгол Улсын Иргэний Хуулийн 78 дугаар зүйлийн 78.1.2 дахь заалтын дагуу түр зогсоно гэж тайлбарлах бүрэн боломжтой байна.

Харин манай улсын Иргэний хуульд ХБНГУ-ын Иргэний хуулийн 781 дүгээр зүйлтэй адил зохицуулалт байхгүй тул тооцоо нийлэх гэрээний талууд харилцан тохиролцох замаар *abstrakte Saldoforderung* буюу үлдэгдлийг төлөхийг шаардах үл хамаарал бүхий буюу хийсвэр эрхийг үүсгэх боломжтой эсэхийг тайлбарлахад нэлээд төвөгтэй. Гэхдээ хувийн чөлөөт байдлын зарчмын үндсэн дээр үүнийг зөвшөөрөх боломжтойн дээр энэ эрхийг үүсгэхдээ заавал эхлээд тооцоо нийлэх гэрээний талууд тооцооны дүнд бий болсон үлдэгдлийг хүлээн зөвшөөрсөн гэрээг байгуулж, түүний дараагаар “үлдэгдлийг төлөхийг шаардах хамаарал бүхий буюу шалтгаант эрх (*kausale Saldoforderung*)” үүсэх бөгөөд уг эрхийг солих замаар шинээр шаардах эрх бий болгож байх тул хууль зүйн тайлбарын хүрээнд хүлээн зөвшөөрөх тодорхой үндэслэл бий.

[Ном зүй]

Б.Тэмүүлэн, Д.Энхзул, Б.Буянхишиг, Иргэний эрх зүй ерөнхий анги (анхны хэвлэл), УБ.,2010 он

Б.Буянхишиг, ХБНГУ-ын Иргэний хууль (кодификацийн бүрэн эх) анхны хэвлэл, УБ.,2017 он

濱田一男、交互計算の法理:比較法的考察、法政研究、40 (1) 1973

Peter Kindler, Grundkurs Handels- und Gesellschaftsrecht, Verlag C.H. Beck, 2009

Roth Weller, Handels- und Gesellschaftsrecht, 7.Aufl.,Vahlen, 2010

Klaus Schreiber, Schuldversprechen und Schuldanerkenntnis, JURA 2014 (1) De Gruyter

Baumbach/Hopt, Handelsgesetzbuch, 33.Aufl.,2008, C.H.Beck

Canaris, Handelsrecht, 24. Aufl.,2006

BGHZ 49, 24, 30

BGHZ 93, 307, 313

RGZ 56, 19

RGZ 132, 218

Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 182/ИШШ2020/01079 дүгээр шийдвэр,

Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 1535 дугаар магадлал

Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал 2023.08.02 №01508

Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал 2022.11.18 №02006

Нийслэлийн Иргэний Хэргийн Давж Заалдах Шатны Шүүхийн Магадлал, 2022 оны 03 сарын 23-ны өдөр, №00550

Нийслэлийн Иргэний Хэргийн Давж Заалдах Шатны Шүүхийн Магадлал, 2023 оны 08 сарын 09-ний өдөр, №01572

Улсын дээд шүүхийн тогтоол 2016.12.01 №01300

Улсын дээд шүүхийн тогтоол 2024.02.20 №00035

[Abstract]

**Interpreting Regulations on Current Account Contract
in the Mongolian Civil Code: Based on Mongolian
Supreme Court Decision, Feb 22, 2022 No.00176**

Renbaa Purevbaatar

Master of Laws (LL.M)

Lecturer of Private Law Department

School of Law, National University of Mongolia

Ulaanbaatar, Mongolia

This research paper examined current situation regarding interpretation and application of regulations of current account contract in the Mongolian Civil Code, and attempts to identify some issues relating to prerequisites, main characteristics of current account contract and its relation between other civil code institutions such as acknowledgement of debt, set-off and so on by conducting comparative analysis. Mongolian legal scholars claimed that private law system of Mongolia, the Civil code of Mongolia, was largely influenced by German private law, especially the German Civil code (BGB) and the German Commercial code (HGB). Some German legal experts (especially – judges from courts of Germany) actively participated in the process of elaboration of the Mongolian Civil Code. Consequently, the regulations of current account contract in the Mongolian Civil Code are similar to article 355 and 356 of HGB and the author decided to compare the regulations of current account in the Mongolian Civil Code and related regulations of the HGB.

[Keywords]

Causal balance claim, acknowledgement of debt, repayment.